



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

Дүүргийн “Явган алхалтын холбоо”-нд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 3.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилтот жил”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд “Бага газрын чулуу 100 км” явган алхалтын арга хэмжээг зохион байгуулахад дүүргийн Явган алхалтын холбоонд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 2,112,000 (хоёр сая нэг зуун арван хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулахыг дүүргийн Явган алхалтын холбоо (М.Ванданхүү)-нд, иргэд, ажилтан албан хаагчдын оролцоог ханган, мэдээлэл, арга зүйгээр дэмжихийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 01 дугаар сарын 01 ны өдрийн
8199 дугаар захирамжийн хавсралт



БАГА ГАЗРЫН ЧУЛУУ 100 КМ-ЫН ЯВГАН АЛХАЛТЫН
АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Шатахуун	л	2640	800	2,112,000
Нийт дүн					2,112,000

